



ҮНДЭСНИЙ ТЕХНИКИЙН ИХ СУРГУУЛИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН СТАНДАРТ

Үндэсний техникийн их сургуулийн багш, судлаач, докторант, магистрант, оюутнууд тодорхой сэдвээр тулгамдаж буй асуудлыг дэвшүүлэн тавьж, тухайн асуудлын учир шалтгаан, хүчин зүйлс хоорондын шалтгаант холбоог танин мэдэх түүнийг нотолсон судалгааны ажил хийж дүгнүүлнэ. Судалгааны ажилд дараах ажлыг оруулан тооцно.

- Судалгааны хэлбэржилт
- Докторын судалгааны ажил
- Магистрын судалгааны ажил
- Дипломын судалгааны ажил
- Ангийн ажил
- Нэг сэдэвт бүтээл
- Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл
- Эсээ

1. Судалгааны хэлбэржилт

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Судалгааны хэлбэржилт нь нэг талаас судлах гэж байгаа зүйл юу болох, хаана, хэзээ, яаж судалгааг явуулах, судалгааг хэрхэн гүйцэтгэх, судалгаагаар цуглуулсан мэдээллээ хэрхэн шинжлэн боловсруулж хэлэлцүүлэх зэрэг үйл явцыг урьдчилан төлөвлөх нөгөө талаас нийгмийн судалганы үндсэн элементүүдийг өөртөө нэгтгэсэн ажлын төлөвлөгөөний нэгтгэл байна.
2	2 Бүрдэл	✚ Сэдэв ✚ Үндэслэл, судалгааны асуудал ✚ Судалгааны асуулт ✚ Судалгааны зорилго, зорилт ✚ Сэдвийн судлагдсан байдлын тойм ✚ Судалгааны таамаглал ✚ Судалгааны арга зүй ✚ Судалгааны хязгаарлалт ✚ Судалгааны ажлын төлөвлөгөө
3	Шаардлага	✚ ҮТИС-ийн салбар сургуулийн гаргасан баталсан сэдвийн хүрээнд судалгаа хийх ✚ Холбогдох эх сурвалжуудыг сайн ашиглаж, мэдээ материалыг логик сайтай, бүрэн цуглуулсан байх ✚ Дизайны бичлэг, хэл найруулга зүйн шаардлагад нийцсэн ✚ Нэр томъёо тодорхойлолтуудыг хоёрдмол утгагүй, товч оновчтой илэрхийлсэн байх

4	Хэлбэр	- Докторын судалгааны ажил - Магистрын судалгааны ажил - Дипломын судалгааны ажил
5	Үнэлгээ	Зөвлөх багийн гишүүд үнэлэх
6	Бичлэг	ҮТИС-ийн стандарт мөрдөх
7	Баталгаажилт	- Удирдагч багшийн зөвшөөрөл - Тэнхим, зөвлөх багшийн зөвшөөрөл

2. Докторын судалгааны ажил

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Тухайн салбар шинжлэх ухааны практикт тулгамдсан асуудлыг дэвшүүлэн тавьж, түүнийг тал бүрээс нь судлан боловсруулж дүгнэсэн тухайн салбарт шинэ мэдлэг бүтээхэд тодорхой хувь нэмэр оруулсан судалгаа шинжилгээний бие даасан бүтээл байна.
2	Үндсэн шаардлага	- Судалгааны дизайн ажлын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх - Сэдвээ судлагдахуун асуудлаа бүрэн хамарч оновчтой томъёолсон байх - Агуулга нь дотоод нэгдэлтэй, логик уялдаатай байх - Боловсруулалтыг өндөр түвшинд хийж, шинжлэх ухааны найруулга зүйн хэм хэмжээг сахих - Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх - Судалгаанаас гарсан дүгнэлт зөвлөмжийг тал бүрээс нь үндсэлж нотлох - Судалгааны үр дүнгээс гадаад дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд 5-оос доошгүй өгүүлэл нийтэлсэн байх
3	Бүтэц	- Удиртгал - Судлагдсан байдлын тойм - Судалгааны арга зүй - Судалгааны өгөгдлийн боловсруулалт шинжилгээ - Дүгнэлт - Эх сурвалжийн жагсаалт - Хавсралт
4	Бичлэг	- ҮТИС-ийн стандарт мөрдөх - Хураангуйг 3 нүүр хуудсанд багтаан англи, орос хэлний аль нэгээр бичиж хавсаргах 100-с доошгүй хуудастай байх
5	Хэлэлцүүлэг хамгаалалт	- Зөвлөх багшийн хэлэлцүүлэг хийх - Тэнхимийн өргөтгөсөн хэлэлцүүлэг хийх - Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалах
6	Үнэлгээ	Докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нууц санал хураалт /маягтын дагуу/
		ҮТИС-ийн нэр лого

7	Гадна нүүр хуудасны бичиглэл	✚ Докторантын овог нэр ✚ Докторын судалгааны ажлын сэдэв ✚ Зэрэг хамгаалуулах мэргэжлийн индекс, нэр ✚ Ямар зэрэг горилохоор бичсэн бүтээл болох ✚ Хотын нэр ✚ Он
8	Дотор нүүр хуудасны бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Докторантын овог нэр ✚ Докторын судалгааны ажлын сэдэв ✚ Зэрэг хамгаалуулах мэргэжлийн индекс, нэр ✚ Ямар зэрэг горилохоор бичсэн бүтээл болох ✚ Хамгаалах үеийн Эрдэм шинжилгээний удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг цол ✚ Хамгаалсны дараа Хамгаалуулах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга, комиссын гишүүдийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Хотын нэр, он

3. Магистрын судалгааны ажил

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Тухайн салбарын удирдлага зохион байгуулалтанд тулгамдсан асуудлыг сонгож шинжлэх ухааны арга зүйг ашиглаж өгөгдөл цуглуулах, боловсруулах, дүн шинжилгээ хийх чадвар эзэмшсэн болохоо нотлон харуулсан судалгааны бүтээл байна.
2	Үндсэн шаардлага	✚ Сэдвээ ухагдахуун асуудлыг бүрэн хамарч, оновчтой томъёолох ✚ Агуулга нь дотоод нэгдэлтэй логик уялдаатай байх ✚ Зохих түвшинд боловсруулж, шинжлэх ухааны найруулга зүйн хэм хэмжээг сахьсан байх
3	Бүтэц	✚ Удиртгал ✚ Судлагдсан байдлын тойм ✚ Судалгааны арга зүй ✚ Судалгааны өгөгдлийн боловсруулалт шинжилгээ ✚ Дүгнэлт ✚ Эх сурвалжийн жагсаалт ✚ Хавсралт
4	Бичлэг	✚ ҮТИС-ийн стандарт мөрдөх ✚ Эрдэм шинжилгээний найруулга зүйн шаардлага хангах ✚ 60-с доошгүй хуудастай байх
5	Хэлэлцүүлэг хамгаалалт	- Судалгааны сэдэв, хүрээг тэнхимийн зөвлөх багаар хэлэлцүүлж баталгаажуулах ✚ Судалгааны ажлыг тэнхимийн зөвлөх багт хамгаалах ✚ Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалах

6	Үнэлгээ	✚ Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн нууц санал хураалт /маягтын дагуу/
7	Гадна нүүр хуудасны бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр лого ✚ Магистрантын овог нэр ✚ Магистрантын судалгааны ажлын сэдэв ✚ Зэрэг хамгаалуулах мэргэжлийн индекс, нэр ✚ Ямар зэрэг горилохоор бичсэн бүтээл болох ✚ Хотын нэр ✚ Он
8	Дотор нүүр хуудасны бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Магистрантын овог нэр ✚ Магистрантын судалгааны ажлын сэдэв ✚ Зэрэг хамгаалуулах мэргэжлийн индекс, нэр ✚ Ямар зэрэг горилохоор бичсэн бүтээл болох ✚ Удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг цол ✚ Шүүмжлэгчийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Хотын нэр, он

4. Дипломын судалгааны ажил

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Тухайн шинжлэх ухааны практикт тулгамдсан асуудлыг сонгон шинжлэх ухааны арга зүй ашиглан өгөгдөл мэдээлэл цуглуулан, боловсруулалт хийсэн үр дүнгийн тайлан
2	Үндсэн шаардлага	✚ Оюутнууд танхимд олж авсан тухайн ухааны мэдлэг чадвараа бататган тодорхой сэдэв, ✚ асуудлаар судалгаа хийж, дүнг нэгтгэх ✚ Судалгааны дизайны дагуу ажиллах ✚ Сэдвээ судлагдахуун, асуудлыг бүрэн хамарч оновчтой томъёолох ✚ Агуулга нь дотоод нэгдэлтэй, логикуялдаатай байх ✚ Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх
3	Дипломын судалгаа гүйцэтгэх оюутныг сонгох үндсэн шаардлага	✚ Мэргэшүүлэх дипломын сургалтад суралцсан хугацаандаа 3.2 ба түүнээс доошгүй багц цаг биелүүлсэн ✚ Судалгааны арга зүй эзэмшсэн судалгаа хийх сонирхолтой
4	Бүтэц	✚ Удиртгал ✚ Судалгааны арга зүй ✚ Судалгааны өгөгдлийн боловсруулалт ✚ Дүгнэлт ✚ Эх сурвалжийн жагсаалт ✚ Хавсралт

5	Бичлэг	✚ УТИС-ийн стандарт мөрдөх
6	Хамгаалалт	✚ Зөвлөх багшийн санал, зөвшөөрөл авах ✚ Хамгаалуулах комисст хамгаалалт хийх
7	Үнэлгээ	✚ Төгсөлтийн шалгалтын комисс дүгнэнэ.
8	Гадна нүүр хуудасны бичиглэл	✚ УТИС-ийн нэр лого ✚ Суралцагчийн овог нэр ✚ Суралцагчийн судалгааны ажлын сэдэв ✚ Мэргэжлийн индекс, нэр ✚ Удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Зөвлөх багшийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Хотын нэр, он
9	Дотор нүүр хуудасны бичиглэл	✚ УТИС-ийн нэр лого ✚ Суралцагчийн овог нэр ✚ Суралцагчийн судалгааны ажлын сэдэв ✚ Мэргэжлийн индекс, нэр ✚ Удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Шүүмжлэгч багшийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг ✚ Хотын нэр, он

5. Ангийн ажил

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Ангийн ажил нь тухайн хичээлийг бүрэн багтаамж агуулгаар нь судалсны дараа оюутан тодорхой нэг асуудлыг сонгон авч онол, практикийн судалгаа хийх, өөрийн үнэлэлт дүгнэлтээ эмхэлж бичих, оюуны бүтээлч үйл ажиллагаа, эрдэм шинжилгээний ажлын эхлэл мөн.
2	Үндсэн шаардлага	✚ Оюутнууд танхимд олж авсан тухайн ухааны мэдлэг чадвараа бататган тодорхой сэдэв, асуудлаар судалгаа хийж, дүнг нэгтгэх ✚ Судалгааны дизайны дагуу ажиллах ✚ Сэдвээ судлагдахуун, асуудлыг бүрэн хамарч оновчтой томъёолох ✚ Агуулга нь дотоод нэгдэлтэй, логик уялдаатай байх ✚ Зохиогчийн эрхийн зөрчилгүй байх
3	Сэдэв	✚ Оюутан тухайн хичээлийг судалж дууссаны дараа болон судалж байх явцдаа тодорхой сэдвийн судлагдсан байдал, ач холбогдол зэргийг тунгааж мэдсэний үндсэн дээр: Ийм зүйл судлах, ярих туршлага буюу онолын бэлтгэл, нийтийн болон цаг үеийн сонирхолд нийцсэн эсэх, хамгийн сүүлийн үеийн ном, лавлах бичиг, сонин сэтгүүлд яаж тусч байгаа, ээдрээтэй асуудал, шинэ шинэлэг санаа бий эсэх сэлтийг бодолцон, тэнхимийн дэвшүүлсэн сэдвээс

		өөрөө сонгоно. ✚ Ангийн ажлын сэдэв нь дараа дараагийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын тухайлбал дипломын, эрдэм шинжилгээний хуралд тавих илтгэлийн улмаар эрдмийн зэрэг горилох ажлын сэдэв байхаар бодолцох нь зүйтэй.
4	Бүтэц	✚ Удиртгал ✚ Судлагдсан байдлын тойм ✚ Судалгааны арга зүй ✚ Судалгааны өгөгдлийн боловсруулалт ✚ Дүгнэлт ✚ Эх сурвалжийн жагсаалт ✚ Хавсралт
5	Бичлэг	ҮТИС-ийн стандарт мөрдөх
6	Хамгаалалт	✚ Удирдагч багшийн санал, зөвшөөрөл авах ✚ Хамгаалуулах зөвлөлд хамгаалалт хийх
7	Үнэлгээ	Хамгаалуулах зөвлөл дүгнэнэ.
8	Нүүр хуудасны бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Суралцагчийн овог, нэр ✚ Судалгааны ажлын сэдэв ✚ Удирдагчийн овог нэр, эрдмийн зэрэг, цол ✚ Удирдагч багшийн овог нэр, эрдмийн зэрэг, цол, гарын үсэг

6. Нэг сэдэвт бүтээл

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Шинжлэх ухааны онол практикийн тодорхой асуудлыг тал бүрээс нь бүрэн судлан боловсруулсан, асуудал дэвшүүлэн шийдвэрлэсэн, эрдэмтэн судлаачдын үзэл баримтлал, санал дүнгэлтүүдийг харьцуулан жишиж, өөрийн байр суурийг тодорхойлсон эрдэм судлалын бүтээл
2	Бүтэц	✚ Удиртгал ✚ Бүлэг, зүйл ✚ Дүгнэлт ✚ Ном зүй ✚ Хавсралт байж болно

7. Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл

№	Стандарт	Агуулга
1	Тодорхойлолт	Судалгааны тодорхой нэг асуудлыг онол практикийн хэрэгцээтэй уялдуулан шинжилж, дүгнэсэн эрдэм шинжилгээний бүтээл

2	Бүтэц	✚ Өгүүлэл /илтгэл/-ийн нэр ✚ Зохиогчийн овог нэр, зэрэг цол, албан тушаал ✚ Түлхүүр үг ✚ Оршил /Авч үзэж байгаа асуудлын мөн чанар, урьд өмнөх судалгааны түвшин, гол онцлогууд, дэвшүүлж буй асуудал/ ✚ Үндсэн хэсэг /онол, арга зүй, судалгаа/ ✚ Дүгнэлт, санал ✚ Ном зүй ✚ Хавсралт байж болно. ✚ Хураангуй /орос, англи хэлний аль нэгээр бичсэн товч танилцуулга/
3	Үндсэн шаардлага	✚ ҮТИС-ийн Судалгаа, боловсруулалтын чиглэлд нийцсэн, улс орны нийгэм, улс төр, эдийн засаг, оюуны амьдралын тулгамдсан, тодорхой асуудлыг судлан авч үзэх ✚ Тухайн асуудлыг онол, практикийн үүднээс судлан боловсруулж, тодорхой үр дүнд хүрсэн, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс үндсэлж нотлох ✚ Судалгааны шинэлэг тал, практик ач холбогдлыг тодорхой гаргах ✚ Илэрхийллийн логик уялдаа, дэс дараалал тодорхой байх ✚ Дэвшүүлсэн санал дүгнэлт оновчтой, тодорхой, практикт нэвтрэх хэрэгжих боломжтой байх
4	Бичлэг	✚ ҮТИС-ийн стандарт мөрдөх ✚ А4 хэмжээгээр 2.0-оос дээшгүй, А5 хэмжээгээр 1.5-аас дээшгүй хэвлэлийн хуудастай байх /хавсралтыг хуудасны тоонд оруулж тооцохгүй/
5	Нүүр хуудсан дахь бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Салбар сургуулийн нэр ✚ Боловсруулалтын ажлын төрөл ✚ Боловсруулалтын ажлын сэдэв ✚ Гүйцэтгэгчийн овог, нэр, зэрэг, цол, анги ✚ Хотын нэр, он

8. Эсээ

№	Стандарт	Агуулга
1	Томъёолол	✚ Эсээ нь тухайн сэдвийн хүрээнд тодорхой асуудал дэвшүүлэн, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлж, дүгнэлт гаргасан зохион бичлэгийн хэлбэр юм. ✚ Эсээ бичих гол зорилго нь суралцагчид танхимд хичээллэх явцдаа эзэмшсэн мэдлэг, чадвараа бататган, тодорхой сэдвээр холбогдох материалуудтай танилцан, шүүмжлэлт, бүтээлч сэтгэхгүйгээр хандан санал, дүгнэлт гаргах ур чадварыг эзэмшүүлэхэд

		чиглэнэ. ✦ Эсээ нь дүрслэн тоочих, хэлэлцүүлгийн, асуудал дэвшүүлсэн гэсэн гурван төрөл байдаг. Үүнээс ҮТИС-ийн сургалтын ажилд асуудал дэвшүүлсэн эсээний төрлийг хэрэглэнэ.
2	Бүтэц	Эсээг бичихдээ багшийн зааврын дагуу ажиллах бөгөөд дараах үндсэн хэсгүүдтэй байна. Үүнд: ✦ Үндэслэл ✦ Эхлэл ✦ Үндсэн хэсэг ✦ Дүгнэлт ✦ Ном зүй
3	Бичлэг	✦ ҮТИС-ийн стандарт мөрдөх ✦ 1000-1500 үгэнд багтаан бичнэ. Тухайн сэдвээр зохион байгуулагч үгийн тоо тогтоож болно.
4	Боловсруулалт хийх	1-р алхам: Бичихийн өмнө ✦ Юуны өмнө ямар чиглэлээр, ямар сэдвийн дор бичихээ сайтар тунгаан, зорилгоо зөв тодорхойлох ✦ Зорилго нь зохиогчийн санал бодлыг бусад хүмүүст үнэмшүүлэх, тэдэнд танин мэдэхүйн шинжтэй мэдлэг олгоход чиглэсэн, сэдэвтэйгээ бүрэн нийцсэн байна. ✦ Зорилгоо тодорхойлсон бол сонирхож буй сэдвээ сонгон, томъёолох ✦ Сэдвээ оновчтой томъёолсон байх нь дараагийн алхмаа зөв хийх үндэс болно. Нарийвчилсан дүгнэлт хийх гэж буй бол та сэдвээ үнэхээр тодорхой томъёолсон эсэхийг эргэн нягтлах шаардлагатай. ✦ Холбогдох мэдээллүүдийг цуглуулан ангилж, боловсруулалт хийх 2-р алхам: Эхний хэсгийг бичих Энэ хэсэгт эсээний товч утга, ерөнхий төлөвлөгөөг тусгана. Эхлэл нь уншигчийн анхаарлыг татахуйц бөгөөд эсээний гол санааг энгийнээр ойлгуулахад оршсон 2-4 өгүүлбэр байна. Төв асуудлын тулгамдсан хэрэгцээ нөхцөл байдлын тухай товч бичнэ 3-р алхам: Үндсэн хэсгийг бичих Үндсэн хэсэг нь сэдвийн агуулгыг илэрхийлсэн гол санаа дэвшүүлэн тавих нь эсээг илүү ойлгомжтой болгодог. Гол санааг дэд санаанууд дэмжих бөгөөд дэд санааг сайтар дэлгэрүүлэн бичиж, жишээ, тайлбар, тоо баримт зэргээр тодруулан баяжуулах хэрэгтэй. Хэрэв та хүсвэл догол мөрийн төгсгөлд дүгнэлтийг өгч болно. 4-р алхам: Дүгнэлт бичих Ерөнхий дүгнэлт нь таны илэрхийлсэн гол санаануудыг нэгтгэсэн 3-4 өгүүлбэрт багтах сүүлчийн хэсэг юм. Дүгнэлт нь сэдвийн бүх гол

		санаанд тулгуурласан таны үзэл бодол байх бөгөөд тухайн сэдвийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлын ач холбогдол, хэрэгжих магадлал, үүсэх үр дагаврыг тодорхойлно. Түүнээс гадна дүгнэлт бичих өөр нэг хэлбэр бол уг сэдвийн хүрээнд авч үзсэн бүхий л асуудлыг нэгтгэн дүгнэж, товчоор “эргэн харах” үйл юм. 5-р алхам: Хянах, засвар хийх Зохиогч биш уншигчийн байр сууринаас дахин нэг уншиж, найруулга болон зөв бичих дүрмийн алдааг засах, бичлэгийн стандартад бүрэн нийцүүлнэ. Эсээний зорилго, сэдэв, утга санаа нягт уялдаатай, агуулга нь логик холбоо сайтай, уншихад хялбар, ойлгомжтой байгаа эсэхийг нягтална. Тухайн сэдэв, агуулгад тохирсон нэр томъёо, үг хэллэгийн илэрхийлэл оновчтой байх нь чухал.
5	Үнэлгээ	✚ Шүүмжлэлт сэтгэлгээ ✚ Хувь хүний үзэл бодол ✚ Бүтээлч үйл ажиллагаа ✚ Үгийн тоо ✚ Бичих ур чадвар ✚ Цаг хугацаанд нь гүйцэтгэсэн эсэх ✚ Санаагаа үндэслэлтэйгээр дэвшүүлсэн байдал ✚ Сэдэв, зорилго, агуулга, дүгнэлтийн уялдаа холбоо
6	Нүүр хуудсан дахь бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Салбар сургуулийн нэр ✚ Эсээний сэдэв ✚ Гүйцэтгэсэн суралцагчийн овог, нэр ✚ Хотын нэр, он

9. Судлагдсан байдлын тойм

№	Стандарт	Агуулга
1	Томъёолол	Судалж буй сэдэвт холбогдолтой ном, судалгааны ажил, эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг уншин шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэсэн бичвэр
2	Бүтэц	Судлагдсан байдлын тоймыг бичихдээ багшийн зааврын дагуу ажиллах бөгөөд тойм нь дараах үндсэн хэсгүүдтэй байна. Үүнд: ✚ Удиртгал ✚ Бүтээлийн хэвлэлийн талаарх мэдээлэл ✚ Агуулгын товч тодорхойлолт ✚ Тухайн асуудлын цаашдын төлвийн талаарх зохиогчдын үзэл бодлын харьцуулалт өөрийн санал дүгнэлтийн хамт

		✚ Дүгнэлт /ерөнхий санаа/
3	Бичлэг	• ҮТИС-ийн стандарт мөрдөх • 5 хуудсанд багтах (Хуудасны тоонд гарчиг, хавсралтыг оруулж тооцохгүй.)
4	Үндсэн шаардлага	✚ Ном, зохиолыг түүвэрлэж уншсан, үндэслэл тодорхой байх ✚ Сонгосон ном зохиолыг хэрхэн уншиж ашигласан аргачлал нь илэрхий байх ✚ Үндсэн агуулгыг харьцуулан ойлгомжтой илэрхийлэх
5	Үнэлгээ	✚ Бичлэг, найруулга зүйн шаардлага хангасан байх ✚ Дүгнэлтийг баримтаар баталгаажуулсан байх
6	Нүүр хуудсан дахь бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Харьяалах сургуулийн нэр ✚ Боловсруулалтын ажлын төрөл ✚ Сэдэв ✚ Гүйцэтгэсэн суралцагчийн овол, нэр, код ✚ • Хотын нэр, он

10. Шүүмж

№	Стандарт	Агуулга
1	Томъёолол	• Бүтээлийн шүүмж гэдэг нь тухайн бүтээлийн онол арга зүйн түвшин, шийдэл, шинэ санаа, үр дүнг нухацтай шүүн тунгааж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгөх судалгааны ажлын нэг төрөл. • Шүүмж бичих гол зорилго нь сэдвийн хүрээнд ямар гол санаа болон мэдлэг агуулагдаж байгаа, эдгээрийн давуу болон дутагдалтай талуудыг илэрхийлэн гаргахад оршино.
2	Бүтэц	Шүүмжийг бичихдээ багшийн зааврын дагуу ажиллах бөгөөд шүүмж нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд: ✚ Агуулга ✚ Давуу болон сул тал ✚ Нэмэлт тодотгол ✚ Дүгнэлт буюу зөвлөмжийн хэсэг
3	Бичлэг	✚ ҮТИС-ийн стандарт мөрдөх ✚ 3 хуудсанд багтах (Хуудасны тоонд гарчиг, хавсралтыг оруулж тооцохгүй.)
4	Үндсэн шаардлага	✚ ҮТИС-ийн боловсруулалтын ажилд мөрдөх стандартыг чанд баримтлах ✚ Тухайн судалгааны тулгамдсан шаардлагыг тодорхойлсон бусад судлаачдын үндэслэл, үзэл баримтлалыг оновчтой тодорхойлох ✚ Хангалттай мэдээ, материал цуглуулсан байх ✚ Өгч байгаа шүүмж нь сэдэв, агуулга, чиглэлд тохирсон байх
5	Боловсруулах аргачлал	1-р алхам: Уншихын өмнөх Тухайн материалыг уншиж эхлэхийн өмнө асуудал

дэвшүүлсэн дараах асуултуудыг өөртөө тавьж болох юм.
Үүнд:

- ✚ Шинжлэх ухааны ямар чиглэлийн бүтээлд, ямар хүрээг хамруулан шүүмж бичих гэж байна вэ?
- ✚ Энэ талаар надад хангалттай мэдлэг байгаа юу?
- ✚ Ямар мэдээллийн эх сурвалж ашиглах вэ?
Хангалттай мэдээлэл, баримт байна уу?
- ✚ Давуу болон сул талыг зөв, оновчтой тодорхойлж болохоор байна уу?
- ✚ Шүүмжээ үр дүнтэй, өгөөжтэй болгохын тулд юунд илүү анхаарах вэ?

2-р алхам: Унших

- ✚ Тухайн материалыг тогтож бүрэн уншина. Уншаад зөвшөөрсөн гэсэн тэмдэглэл хийнэ. Эрт дүгнэлт хийхээс татгалзах хэрэгтэй.
- ✚ Зохиогчийн гол санааг өөрийн үгээр нэг өгүүлбэрт багтаан томъёолно. Тухайн материалыг бүрэн дүүрэн уншаагүй, эсвэл зохиогч гол санаа зорилгоо бүрэн тайлбарлан гаргаагүйгээс болж гол санааг томъёолж чадахгүйд хүрч болох талтай.
- ✚ Зохиогчийн санаа зорилгыг хүчтэй дэмжиж байгаа, эсвэл сул болгох юмуу үгүйсгэж байгаа хэсэгт анхаарлаа хандуулна. Мөн будлиантай, тодорхой бус, уялдаагүй эсвэл буруу байгаа хэсгүүдийг анхаарч тэмдэглэл хийнэ.

3-р алхам: Шүүмж бичих

Шүүмж бичихдээ дараах шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг нягтална.

- ✚ Сэдэв агуулга хоёр хоорондоо уялдаж байгаа эсэх. Хэрэв сэдэв буруу томъёолсон бол түүнийг хэрхэн засах талаар санал дэвшүүлэх
- ✚ Тухайн зүйлийг яг хэнд зориулж бичсэн бэ? гэдгийг анхаарч тооцох
- ✚ Шүүмжлэхийн сацуу тодорхой зөвлөмж өгөх
- ✚ Тухайн ажилд орхигдсон 2-оос доошгүй санал гаргаж бичих
- ✚ Зохиогчийн санаа зорилго, дүгнэлтийг харуулж чадах баталгаа нотолгоонуудыг нэгтгэх. Тухайн сэдвийн талаар хангалттай нотолгоо гаргаж чадаагүй байх юм бол үүнийг шударгаар илчилнэ. Гэхдээ тодорхой жишээ баримт гаргаж нотолно.
- ✚ Тодорхой цаг үеийн шинжтэй, чамбай судалгаа болж чадсан уу, үгүй юу? гэдгийг нягтлах.
- ✚ Эх сурвалжуудыг ашиглаж буй хэсэгт зохиолчийн судалгаа болоод бусад хүмүүсийн хийсэн судалгааны хооронд зохистой тэнцвэр байгаа эсэхийг нягтлах
- ✚ Тухайн сэдвийн хүрээнд зохиогч тавьсан зорилго, зорилтдоо бүрэн хүрч чадсан эсэхийг тайлбарлах
- ✚ Уялдаа холбоо нь сул, задлан шинжилгээ бүрэн бус, дүгнэлт нь буруугэх мэт тал дээр илүү анхаарах
- ✚ Хэл найруулгын талаар шүүмжлэлтэй хандах

		✚ Зохиогчийн хэрэглэсэн арга аргачлал, бичлэгийн хэв маягийг үнэлж цэгнэх
6	Үнэлгээ	Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг хичээлийн хөтөлбөрт багтаан танилцуулна.
7	Нүүр хуудсан дахь бичиглэл	✚ ҮТИС-ийн нэр, лого ✚ Харьяалах сургуулийн нэр ✚ Боловсруулалтын ажлын төрөл ✚ Сэдэв ✚ Гүйцэтгэсэн суралцагчийн овог, нэр, код ✚ Хотын нэр, он

10. Кэйс

№	Стандарт	Агуулга
1	Томъёолол	✚ Тодорхой шийдэл шаардагдаж буй тулгамдсан асуудлыг дэвшүүлж, тухайн хичээлээр эзэмшсэн мэдлэг, чадвартаа үндэслэн шинжилгээ хийх зориулалттай бичсэн ажил. ✚ Кэйс нь суралцагчдад анхлан нүүр тулах боломжгүй тодорхой асуудалтай танилцан, оношилж судлах чадвараа сайжруулах боломж олгодог.
2	Бүтэц	✚ Оршил ✚ Үндсэн хэсэг ✚ Шийдвэрлэх арга зам ✚ Шийдвэр болон зөвлөмж ✚ Ашигласан материал
3	Үндсэн шаардлага	✚ ҮТИС-ийн боловсруулалтын ажилд мөрдөх стандартыг чанд баримтлах ✚ Тухайн хичээлийн тодорхой сэдвийн дор боловсруулах ✚ Тулгамдсан асуудал, шалтгаан болон үр дагавар, оролцогч талуудын үүрэг, шийдвэр гаргахад шаардлагатай нотолгоо зэргийг оновчтой тодорхойлох ✚ Судалгааны аргууд /Свот анализ, гадаад, дотоод орчны шинжилгээ, Смарт г.м/-ыг оновчтой сонгон хэрэглэх. ✚ Шинэ мэдээлэл агуулах ✚ Хэт тайлбарлахын оронд шинжлэх тал дээр илүү анхаарах ✚ Судалгааны сайн эх үүсвэр ашиглах
4	Бичлэг	✚ ҮТИС-ийн стандарт мөрдөх ✚ 8 хуудсанд багтаах (Хуудасны тоонд гарчиг, ашигласан материалын жагсаалт, хавсралыг оруулж тооцохгүй.)
5	Бичих алхмууд	✚ Тухайн сэдвийн онцлогт тохирох сонирхолтой санаа, маргаантай асуудал юу байна гэдгийг судлах ✚ Таны сонгосон ерөнхий чиглэлд хамаарах асуудалд

		ямар хэмжээний мэдээлэл шаардлагатай вэ гэдгийг мэдэрч, хүрээг нь хязгаарлаж, судлах гэж буй тухайн сэдэврүүгээ хандуулах + Тоо баримт тодорхой, бодитой эсэх, мэдээллийн эх сурвалж бүрэн эсэхийг сайтар нягтлах + Цуглуулсан мэдээ материалдаа шинжилгээ хийж, сонгосон сэдэвтээ хэрхэн тохируулж ашиглахаа шийдэх + Шийдэх ёстой үйл явдлуудыг товчоолох + Кэйсээ бичих + Танилцуулга /presentation by power point/ бэлтгэх
6	Үнэлгээ	+ Нөхцөл байдлыг оношилж, шинжилгээ хийсэн байдал + Судалгааны арга, арга зүй эзэмшсэн байдал + Шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байдал + Танилцуулга хийж, хэлэлцүүлэгт оролцсон байдал
7	Нүүр хуудсан дахь бичиглэл	+ УТИС-ийн нэр, лого + Харьяалах сургуулийн нэр + Боловсруулалтын ажлын төрөл + Сэдэв + Гүйцэтгэсэн сралцагчийн овог, нэр, код + Хотын нэр, он